



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаан-Уул

Монгол хэл бичгийн талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1, дахь заалт, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ийн 2.1 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрийн албан хаагчдаар “Хүмүүн бичиг” сонинг захиалуулж, улирал тутам албан хаагчдын сонин захиалга, үндэсний бичгийн хэрэглээний түвшингийн талаар тайлан ирүүлж, үр дүнг цалин урамшуулалтай тооцож ажиллахыг байгууллагуудын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2. Төрийн байгууллагын албан хаагчдыг үндэсний бичгээ шамдан сурах крилл бичгээр найруулга зүйн алдаагүй зөв бичих чадварыг дээшлүүлэхэд арга зүйгээр хангаж ажиллахыг Хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3. Монгол үндэсний бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Г.Баасанжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642101155